

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гүнчинхорол	Дугаар	L352
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Хулд
Төрсөн газар	Сайхан-Овоо сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хутагт ламын хийд, Шаверын хашаатын хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 016,
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны7-рсарын 13	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хутагт ламын хийд, Шаверын хашаатын хийд

Жужа: Эхлээд энэ Хутагт ламын хийдийн талаар асууна.

Гүнчинхорол: Тэр Богд уул гэдгийн өвөр дээр хурлын газар нь байсан юм. Тэгээд тэнд шашны талын л лам хуваргууд байсан юм. Лам хуваргууд ч яахав дээ ард түмний хүүхдийг зааж сургаж, нэгээр яривал тийм хүмүүжилд л оруулж байсан тийм л газар байгаа юм. Номоо уншиж, хурал хийж буйн хийж байдаг тийм л газар. Тэгээд л яахав тэр буянаа хийлгүүлээ гэдэг чинь олон л амьтан байсан юм л даа. Үр хүүхдэдээ багшлуулж , одоогоор бол сургууль.

Жужа: Ойролцоогоор хэдэн лам байсан бэ?

Гүнчинхорол: 40, 50-иад лам байсан байх.

Жужа: Хэдэн дуган байсан бэ?

Гүнчинхорол: 6 том дуган байсан. Цогчин дуган гэж их том дуган байсан. Зарим лам нар нь гэрт, зарим лам нар нь байшинд байсан. Хүүхдүүдэд тэр буяныхаа номыг зааж өгдөг. Одоогоор бол сургуулийн л газар байсан даа. Ард түмэн их очиж мөргөдөг, энэ яваа, хойд насаа даатгадаг.

Жужа: Юугаар хийсэн дуган байсан бэ?

Гүнчинхорол: Өө жижигхэн түүлийн тоосгоор л хийсэн байсан.

Жужа: Суварга байсан уу?

Гүнчинхорол: Суварга байсан, нэлээн олон суварга байсан. Хүүхэд байсан бас очиж мөргөдөг л байсан.

Жужа: Хашаанд байсан уу, хашааны гадна байсан уу?

Гүнчинхорол: Хашаагүй байсан байх шүү. Энхийг юунд тэмдэглэдэг юм бол доо?

Жужа: Хуучны сүм хийдүүдийн талаар настай хүмүүсээс өөр хүн мэддэггүй.

Энхбаяр: Шаверын хашаатын хийдийн тухай?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гүнчинхорол: Тэр бол бага хийд байсан. Бас л хүүхдүүдэд ном заасан, цөөхөн ламтай байсан.

Энхбаяр: Нэг л дуган байсан уу?

Гүнчинхорол: Тийм.

Энхбаяр: Тоосгон дуган байсан уу?

Гүнчинхорол: Тоосго байсан.

Энхбаяр: Хашаатай байсан уу?

Гүнчинхорол: Хашаагүй байсан санагдаад байна. Дуганд нь мөргөж байсан, хашаагүй л байсан санагдаж байна.

Ер нь дуганууд хашаагүй, зүгээр дугантай, суваргатай. Дуган гэдэг бол бурхан номтой, хурал хурсан тийм газар. Бага байсан болоод тэр дуган энэ тэрийг сайн мэдэхгүй байна.

Жужа: Хашаатын хийдэд суварга байсан уу?

Гүнчинхорол: Байсан.Тэр хурлын газар чинь ер нь заавал суваргатай л байсан байх. Тэнд Хашаатын хуралд сүүж

байсан хүүхдүүд тэгээд л байж байгаад л хойгуур явж байгаад л тэгээд...

Энхбаяр: Хашаатын хийдийн хамба нь ямар хүн байсан юм, та мэдэх үү?

Гүнчинхорол: Аа мэдэхгүй. Энэ хийд дээр бол тэр Гомбосоо ван гэж байсан юм. Бусад амьтан ирвэл ерөөсөө түүнийг багш л гэдэг байсан шүү, нэрээр нь хэлэхгүй.

Энхбаяр: Та жилийн дүйчэн өдрийн хуралд очиж байсан уу?

Гүнчинхорол: Очиж байгаагүй, ганц нэг л очсон байх. Намайг хүүхэд байхад тэр чинь тэгээд шүтлэгийн юм муутай байсан байх л даа. Тэр социализмын үед чөлөөтэй юм байхгүй.Түүрүүнийхийг бол сайн мэдэх юм байхгүй.

Энхбаяр: Энэ хоёр хийд чинь гучин долоон онд хаагдсан?

Гүнчинхорол: Хэдэн онд ч хаагдаа, багачуулыг нь хөдөө гаргаад л .Тэгээд нэг цэргийн насныхыг нь бүртгэл аваад л, хөдөө гаргаад, ахмад настайгуудаас нь эрдэмтэй энэ тэр лам нарыг нь бариад л байсан шүү. Нэгээр яривал хариугүй тахир, дутуу энэ тэр тиймэрхүү ганц нэг хүн үлдэж байсан байх аа. Тэгээд л нөгөөхийг чинь үзэж хараад л , юмнуудыг нь буулгаж аваад л .Тэгээд л үлсүүд нь дүрвэж гараад л.Арай том хутагт, дээгүүр зиндааны лам энэ тэрээс нь л эхэлж бариад л .30 гаран насныхыг нь 10 жил өгөөд л , хорин хэдэн насныхыг нь бүртгэл аваад л , цэрэгт явуулахыг нь явуулаад л, хүүхдүүдийг нь тэр хүүхдүүд чинь л одоо Бат-Эрдэнийн эцэг тэр дулий өвөө энэ тэр чинь хүүхдүүдэд нь орж байгаа юм.